

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТЭС СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Х.БЯМБАЖАВ ТАНАА

2023.02.24 № УВА-2023/67/НА-ТШБ-СТА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

E:/sta-2023/A4-blank.docx

0200200405

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,764,374.00</u>	<u>4,161,098.00</u>
33	АВЛАГА	56,774.00	9,098.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	56,774.00	9,098.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,707,600.00	4,152,000.00
354	Хангамжийн материал	1,707,600.00	4,152,000.00
35410	Бичиг хэргийн материал	230,500.00	292,000.00
35420	Аж ахуйн материал	1,359,100.00	1,992,000.00
35470	Бусад хангамжийн материал	118,000.00	1,868,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,026,905.68</u>	<u>14,700,365.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,026,905.68	14,700,365.76
392	Биет хөрөнгө	17,026,905.68	14,700,365.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	14,636,000.00	15,786,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,229,499.74	-9,944,699.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,263,400.00	16,263,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,642,994.58	-7,404,334.66
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>18,791,279.68</u>	<u>18,861,463.76</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>1,441,840.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	1,441,840.00
413	Өглөг	00.00	1,441,840.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,241,840.00
4136	Бусад өглөг	00.00	200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>18,791,279.68</u>	<u>17,419,623.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	18,791,279.68	17,419,623.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,032,600.00	1,032,600.00
51101	Өмч: - төрийн	1,032,600.00	1,032,600.00
512	Хуримтлагдсан үр дүн	17,758,679.68	16,387,023.76
51210	Өмнөх үеийн үр дүн	17,758,679.68	17,758,679.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,371,655.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>18,791,279.68</u>	<u>18,861,463.76</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>108,379,200.00</u>	<u>96,640,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>10,973,000.00</u>	<u>00.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	10,973,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,973,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,973,000.00	00.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,406,200.00	96,640,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,906,200.00	96,640,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,906,200.00	96,640,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	97,825,009.12	98,012,355.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,825,009.12	98,012,355.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,867,622.12	96,230,058.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,102,756.00	60,357,491.00
210101	Үндсэн цалин	36,386,894.00	28,581,200.04
210102	Нэмэгдэл	00.00	7,139,289.83
210104	Урамшуулал	24,715,862.00	24,637,001.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,332,075.00	7,544,677.35
210201	Тэтгэврийн даатгал	6,070,589.88	6,952,548.16
210202	Тэтгэмжийн даатгал	385,371.28	148,032.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	308,297.30	118,425.96
210204	Ажилгүйдлийн даатгал	797,073.98	29,606.34
210205	Эрүүл мэндийн даатгал	770,742.56	296,064.59
2104	Хангамж, бараа материалын зардал	9,494,350.00	4,488,200.00
210401	Бичиг хэрэг	815,000.00	1,128,600.00
210402	Тээвэр, шатахуун	8,044,350.00	2,628,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	369,000.00	724,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	266,000.00	7,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	8,880,000.00
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	8,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,000.00	4,509,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	4,419,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	74,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,520,441.12	10,449,889.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,084,660.00	1,917,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,553,400.00	5,055,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,882,381.12	3,476,539.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,957,387.00	1,782,297.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,679,800.00	1,726,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,366,600.00	1,726,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,277,587.00	56,297.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,277,587.00	56,297.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,554,190.88	-1,371,655.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,500.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	12,500.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-12,500.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,541,690.88	-1,371,655.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	97,406,200.00	96,640,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,406,200.00	96,640,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	96,906,200.00	96,640,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	96,906,200.00	96,640,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	97,406,200.00	95,490,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,406,200.00	95,490,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,448,813.00	93,708,402.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,102,756.00	59,211,850.83
210101	Үндсэн цалин	36,386,894.00	28,677,400.00
210102	Нэмэгдэл	00.00	7,139,289.83
210104	Урамшуулал	24,715,862.00	23,395,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,348,147.00	7,400,801.52
210201	Тэтгэврийн даатгал	6,086,661.88	6,808,672.33
210202	Тэтгэмжийн даатгал	385,371.28	148,032.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	308,297.30	118,425.96
210204	Ажилгүйдлийн даатгал	797,073.98	29,606.34
210205	Эрүүл мэндийн даатгал	770,742.56	296,064.59
2104	Хангамж, бараа материалын зардал	7,842,910.00	3,640,370.00
210401	Бичиг хэрэг	698,000.00	367,500.00
210402	Тээвэр, шатахуун	6,567,910.00	2,363,870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	369,000.00	724,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	208,000.00	185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,490,000.00	339,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	339,900.00
210602	Тавилга	1,490,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	8,880,000.00
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	8,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	218,000.00	4,509,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	4,419,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	74,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,247,000.00	9,725,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,859,600.00	4,407,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,387,400.00	5,318,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,957,387.00	1,782,297.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,679,800.00	1,726,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,366,600.00	1,726,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,277,587.00	56,297.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,277,587.00	56,297.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,150,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,150,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,150,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,150,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,032,600.00	00.00	17,758,679.68	18,791,279.68
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,032,600.00	00.00	17,758,679.68	18,791,279.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,032,600.00	00.00	17,758,679.68	18,791,279.68
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,371,655.92	-1,371,655.92
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,032,600.00	00.00	16,387,023.76	17,419,623.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,640,700.00	96,584,402.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,640,700.00	96,584,402.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,914,100.00	94,858,402.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,212,900.00	59,211,850.83
210101	Үндсэн цалин	34,106,900.00	28,677,400.00
210102	Нэмэгдэл	00.00	7,139,289.83
210104	Урамшуулал	25,106,000.00	23,395,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,401,600.00	7,400,801.52
210201	Тэтгэврийн даатгал	7,401,600.00	6,808,672.33
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	148,032.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	118,425.96
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	29,606.34
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	296,064.59
2104	Хангамж, бараа материалын зардал	3,650,500.00	3,640,370.00
210401	Бичиг хэрэг	349,900.00	367,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,368,000.00	2,363,870.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	724,500.00	724,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	208,100.00	185,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,499,400.00	1,489,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,499,400.00	1,489,900.00
2107	Томилолт, зочны зардал	8,880,200.00	8,880,000.00
210702	Дотоод албан томилолт	8,880,200.00	8,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,516,300.00	4,509,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,426,300.00	4,419,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	90,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9753200.00	9725680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,433,800.00	4,407,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,319,400.00	5,318,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1726600.00	1726000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,726,600.00	1,726,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,726,600.00	1,726,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,640,700.00	96,584,402.35
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	96,640,700.00	96,584,402.35
132001	Орон нутгийн төсвөөс	96,640,700.00	96,584,402.35
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	2	2
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	1	1
620003	Үйлчлэх ажилтан	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бие даан зохион байгуулах гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 70.2 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	56.8	9.1	-47.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	1,707.6	4,152.0	2,444.4
Үндсэн хөрөнгө	17,026.9	14,700.4	-2,326.5
Нийт хөрөнгө	18,791.3	18,861.5	70.2
Өр төлбөр		1,414.9	-1,414.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	18,791.3	17,446.6	-1,344.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,791.3	18,861.5	70.2

Бараа материалын дансны үлдэгдэл 4,152.0 мянган төгрөг болж 2,444.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал худалдан авснаас шалтгаалж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 14,700.4 мянган төгрөг болж 2,326.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,446.6 мянган төгрөг болж 1,344.7 мянган төгрөгөөр буурсан нь нь хөрөнгийн хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 134,365.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 134,365.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37,724.7 мянган төгрөгөөр бууруулж 96,640.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 96,640.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 96,640.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 96,640.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 96,584.4 мянган төгрөгийг зарцуулж, 56.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96,584.4 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зардлыг 56.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101	62,042.7	62,018.1	24.6	99.9
2	80205	193.4	190.0	3.4	98.2
3	80802	1,726.6	1,726.0	0.6	99.9
4	80825	28,244.2	28,243.1	1.1	99.9
5	82201	4,433.8	4,407.2	26.6	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 98.0 сая төгрөгийн 2.0 хувь буюу 2.0 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 1.6 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроож байршуулсан 2, байршуулаагүй 12, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шилэн дансны цахим хуудаст 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 8,520.0 мянган төгрөгийн 5 мэдээлэл,

4,472.3 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	2,182.5	1	2,182.5	100
Зөвлөмж					
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,992.3 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага өглөө.

5.2 Албан шаардлага

Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шилэн дансны цахим хуудаст 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 8,520.0 мянган төгрөгийн 5 мэдээлэл, 4,472.3 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 7 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн.	1	12,992.3			1	12,992.3		
Дүн	1	12,992.3				12,992.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	12,992.3			1	12,992.3		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 17-ны өдөр